



**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 21 өдөр


Дугаар 13

Улаанбаатар хот

ШУТИС-ийн 2018 оны зарлагын төсөвт
өөрчлөлт оруулах тухай

Монгол улсын боловсролын тухай хуулийн 36.12.3 дугаар заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.5 дугаар заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 12 сарын 21-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. ШУТИС-ийн 2018 оны үйл ажиллагааны батлагдсан зарлагын төсвийн нийт дүнг өөрчлөхгүйгээр, зардлын төрөл ангиллыг хавсралтад заасан дүнд багтаан шилжүүлэн зарцуулахыг зөвшөөрсүгэй.
2. Төсвийн гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг ШУТИС-ийн захирал Б.Очирбат, Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал Л.Баяр-Эрдэнэ нарт даалгасугай.





**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2018 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 14

Улаанбаатар хот

ШУТИС-ийн 2019 оны төсөв батлах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.3 дугаар заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.4 дүгээр заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хуралдаанаас тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2019 оны үйл ажиллагааны орлогын төсвийг 1-р хавсралтаар, зарлагын төсвийг 2-р хавсралтаар, хөрөнгө оруулалт, бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг 3-р хавсралтаар тус тус баталсугай.
2. Төсвийн гүйцэтгэлийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж, батлагдсан төсвийн дагуу захиран зарцуулах зохион байгуулалтын арга хэмжээг авч ажиллахыг ШУТИС-ийн захирал Б.Очирбат, Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал Л.Баяр-Эрдэнэ нарт даалгасугай.
3. ШУТИС-ийн эрдэм шинжилгээ, инновацийн үйл ажиллагааны санхүүжилт, орлогыг нэмэгдүүлж ажиллахыг ШУТИС-ийн захирал Б.Очирбат, Эрдэм шинжилгээ, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал Т.Намнан нарт даалгасугай.



ДАРГА

Б.ГАНБАТ



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

Ахисан түвшний сургууль байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36.12.2, Дээд боловсролын тухай хуулийн 12.1.5, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.7, ШУТИС-ийн Дүрмийн 3.3.2, Судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр, Удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Бизнесийн Ахисан түвшний сургуулийг 2019 оны 01-р сарын 02-ны өдрөөс ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль болгон өөрчлөн зохион байгуулсугай.
2. ШУТИС-ийн Инженерийн ахисан түвшний сургуулийг эрчим хүч, мэдээлэл, холбооны технологи, механик инженерийн салбаруудтайгаар 2019 оны 1-р улиралд багтаан байгуулсугай.
3. Инженерийн ахисан түвшний сургуулийн Эрчим хүч, мэдээлэл, холбооны технологи, механик инженерийн ахисан түвшний салбаруудыг Эрчим хүчиний сургууль, Мэдээлэл холбооны технологийн сургууль, Механик тээврийн сургуулиудыг түшиглүүлэн 2019 оны 1-р улиралд байгуулахыг зөвшөөрсүгэй.
4. Дээрх зохион байгуулалтын өөрчлөлттэй холбогдуулан, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг захирал /Б.Очирбат/-д үүрэг болгосугай.
5. Энэхүү тогтоолын хэрэгжилтийн үр дүнг 2019 оны 2-р улиралд багтаан Удирдах зөвлөлд танилцуулахыг захирал /Б.Очирбат/-д даалгасугай.





ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 21 өдөр


Дугаар 16

Улаанбаатар хот

ШУТИС-ийн бүрэлдэхүүн сургууль
байгуулах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36.12.2, Дээд боловсролын тухай хуулийн 12.1.5, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.7, ШУТИС-ийн Дүрмийн 3.3.2, Удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

- Гадаад хэлний институтийг 2019 оны 1-р улиралд багтаан, ШУТИС-ийн бүрэлдэхүүн Гадаад хэлний сургууль болгон өөрчлөн зохион байгуулсугай.
- Бүрэлдэхүүн сургууль байгуулагдсантай холбогдуулан, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг захирал /Б.Очирбат/-д үүрэг болгосугай.





ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 17

Улаанбаатар хот

ШУТИС-ийн зарим нэгжийн бүтэц, зохион
байгуулалтыг өөрчлөх тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36.12.2, Дээд боловсролын тухай хуулийн 12.1.5, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.7, ШУТИС-ийн Дүрмийн 3.3.2, Удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. ШУТИС-ийн бүрэлдэхүүн Е-Нээлттэй институтийг 2019 оны 1-р улиралд багтаан татан буулгаж, Нээлттэй боловсролын төв болгон өөрчлөн зохион байгуулсугай.
2. ШУТИС-ийн захиргааны бүтцийг нэгдүгээр хавсралтад заасны дагуу шинэчлэн баталж, 2019 оны 01-р сараас мөрдсүгэй.
3. ШУТИС-ийн захиргааны бүтцэд өөрчлөлт оруулсантай холбогдуулан, Сургалтын хөтөлбөрийн бүртгэлийн алба, Хөгжлийн үзүүлэлт, статистикийн алба, Багшийн хөгжлийн төв, Олон улсын дээд боловсрол судлалын төвийг тус тус татан буулгасугай.
4. ШУТИС-ийн захиргааны бүтцэд Бүртгэлийн нэгдсэн алба, Технологи дамжуулах төв, Нээлттэй боловсролын төвийг тус тус 2019 оноос байгуулсугай.
5. ШУТИС-ийн зарим нэгжийн бүтцэд өөрчлөлт орсонтой холбогдуулан холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэн, Удирдах зөвлөлийн даргад танилцуулахыг захирал /Б.Очирбат/-д үүрэг болгосугай.



Б.ГАНБАТ



ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2018 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот

Сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авах
хүсэлт гаргах тухай

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.12.2 дахь заалт, Дээд боловсролын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.5 дахь заалт, БСШУ-ны Сайдын 2010 оны 353 дугаар тушаал, Үйлдвэрийн инженер, технологичийг бэлтгэх технологийн коллежийн сургалтын хөтөлбөрт тавих нийтлэг шаардлагын 2.2.1 дүгээр заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн тогтоох нь:

1. ШУТИС-КООСЭН Технологийн коллежид бүрэн дунд боловсролын сургалт эрхлэх тусгай зөвшөөрөл авах хүсэлтийг БСШУСЯ-нд уламжилсугай.

ДАРГА

Б.ГАНБАТ





ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 12 сарын 21 өдөр

Дугаар 19

Улаанбаатар хот

Хичээлийн байрны төлөвлөлтийг шинэчлэх тухай

Боловсролын тухай хуулийн 36.12.3, Дээд боловсролын тухай хуулийн 11.6.1, Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.3 дугаар заалтууд, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2016 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 05 тоот тогтоол, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. ШУТИС-ийн хичээлийн 4-р байрны шинэ барилгыг барихтай холбогдуулан, одоо ашиглаж байгаа барилгыг буулгах, дахин төлөвлөлт хийхийг дэмжсүгэй.
2. ШУТИС-ийн хичээлийн 4-р байрны техникийн даалгавар боловсруулах, зураг төслийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах, тендер зохион байгуулах, шинээр барих барилгын зураг төслийн санхүүжилтийг ШУТИС-ийн 2019 оны төсөвт тусгахыг ШУТИС-ийн захирал /Б.Очирбат/, Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал /Л.Баяр-Эрдэнэ/, Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал /Б.Сүхбат/ нарт даалгасугай.
3. ШУТИС-ийн хичээлийн 4-р байрны шинэ барилгыг барихтай холбогдуулан, одоо ашиглаж байгаа барилгыг буулгах замаар ашиглалтаас хасаж, барилгын талбайг чөлөөлүүлэх саналыг БСШУСЯ, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газарт тус тус уламжилсугай.
4. Хуучин барилгыг буулгах, шинээр барилга барих төсвийг 2020 оны улсын төсөвт тусгуулах саналыг боловсруулан, БСШУСЯ-нд уламжилж шийдвэрлүүлэх арга хэмжээ авахыг ШУТИС-ийн захирал /Б.Очирбат/, Хөгжлийн бодлого, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал /Б.Сүхбат/, Санхүү, хөрөнгө оруулалт эрхэлсэн дэд захирал /Л.Баяр-Эрдэнэ/ нарт даалгасугай.

ДАРГА



Ганбат

Б.ГАНБАТ